

**УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/103/-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885

Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал
Утас: 261740

Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал С.Тунгалаг

Утас: 70001778

Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn

Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сожидмаа

Утас: 70001778

Цахим хаяг: sojidmaa.s@imkaudit.mn

Аудитор: Д.Пүрэвжаргал

Утас: 70001778

Цахим хаяг: purevjargal.d@imkaudit.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	1
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....	2
2.5	Дотоод хяналт	2
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар</i>	<i>3</i>
2.9.2	<i>Мөнгөн хөрөнгийн талаар.....</i>	<i>3</i>
2.9.3	<i>Үндсэн хөрөнгийн талаар</i>	<i>4</i>
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	4
3	Менежментийн захидал	5
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	6
	Үндсэн хөрөнгийн талаар	7
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	8
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТГЭРЭЛ ТАНАА

2018.02.23 № 06/477
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит, тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Улаанбаатар хот дахь гаалийн газрын дарга Б.Батгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 26-наас 2018 оны 2 дугаар сарын 21-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитор Д.Пүрэвжаргал, аудиторов туслах М.Батжаргал, Б.Эрдэнэ, Д.Батдэлгэр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/71 дүгээр албан бичгээр “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар хот дахь Гаалийн газар санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, САГ-2018/103/СТА-ТШЗ

тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны төсвийн санхүүжилтийг Сангийн сайдын багцаас олгосон байна.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт нь дэвшилтэт технологид суурилсан, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлж, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэгч гаалийн байгууллага болох.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийг системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах, гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал болно.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 30 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Улаанбаатар хот дахь гаалийн газар” нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” гэж үзлээ.

Гаалийн Ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2014, 2015, 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, байгууллагын САГ-2018/103/СТА-ТШЗ

хэмжээнд “Сайжруулалт хэрэгтэй” гэсэн дүгнэлт өгсөн байна. Санхүү төсөвтэй холбоотой 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд 2017 онд 3,420,697.6 мянган төгрөгийн санхүүжилтийн, 58,854.0 мянган төгрөгийн түрээсийн орлогын, 6,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн, нийт 3,485,551.6 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталснаас улсын төсвийн болон нэмэлт санхүүжилт бүрэн хийгдэж, түрээсийн орлогыг 100 хувь төвлөрүүлсэн байна. Тайлант онд 3,514,813.9 мянган төгрөгийн зардлын төсөв батлагдснаас 3,485,551.6 мянган төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй, 99.1 хувийн биелэлттэй байгаа нь цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, нийтлэг төлбөр хураамжийн зардлууд дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Түрээсийн орлогын 30 хувь буюу 17,711.7 мянган төгрөгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 41,711.2 мянган төгрөгийг төв төрийн санд төвлөрүүлсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай 18 төрлийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

А. Гаалийн ерөнхий газрын даргын 2014 оны А/14 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт элэгдэл тооцох арга, ашиглах хугацааг тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", УСНББОУС 3.15-д “Аливаа зүйлсийн ангилалд өөр бодлого хэрэглэх нь зохистой гэж УСНББОУС-д тусгайлан шаардсан, эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага ижил төрлийн гүйлгээ, бусад үйл явдал буюу, нөхцөл байдлыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай сонгож мөрдөнө. Хэрэв УСНББОУС ийм ангилалыг шаардсан эсвэл зөвшөөрсөн бол тухайн ангилал бүрд тохирох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай сонгож хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт элэгдэл тооцох арга, хөрөнгийн ашиглах хугацааг нэмж тусгуулах зөвлөмж өгөх.

2.9.2 Мөнгөн хөрөнгийн талаар

А. Нийт 66,528.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ өглөгийн дансаар дамжуулаагүй тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.10-ыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хөрөнгийн тооцооны дансдад бичилт хийхгүйгээр шууд зардлын дансанд бичсэн 66,528.4 мянган төгрөгийн гүйлгээг холбогдох дансдад залруулан бүртгэж, тайлагнах дансны залруулга хийлгэв.

2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

А. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 209.0 мянган төгрөгийн дутуу байгуулсан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн /УСНББОУС/ 3.66-д “Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр элэгдүүлнэ” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тооцсон элэгдлийг залруулж, санхүүгийн үр дүнгийн тайланг залруулав.

Б. Хөрөнгө шилжүүлэх тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/103 дугаар тушаалын хавсралтад заасан хөрөнгийг шилжүүлэхдээ 700.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” зарчим, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө данснаас хасах, шилжүүлэхдээ элэгдлийг үнэн зөв тооцоолж байх Зөвлөмж өгөв.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц зүйл гараагүй.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар авч үзэх асуудлууд гараагүй.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 67,437.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 66,737.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 700.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,727,192.1 мянган төгрөг бөгөөд 2 хувиар буюу 74,543.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Энэхүү материаллаг байдлын дүн нь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 522.9 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь төлөвлөлтийн шатанд нийт зардлын дүнд оруулж тооцоогүй, үндсэн хөрөнгө худалдсны гарз 26,165.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй гарсан 1,971.2 мянган төгрөгийн зардлыг нэмж тооцсноос шалтгаалж байна.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Улаанбаатар хот дахь гаалийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Хөрөнгө шилжүүлэх тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/103 дугаар тушаалын хавсралтад заасан хөрөнгийг шилжүүлэхдээ 700,142.13 хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” зарчим, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн өөрчлөлт оруулж, санхүүгийн тайлан гаргахдаа мөрдлөг болгон ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Үйл ажиллагааны зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол ᠙1
-------------------------	---------------------------

Ажиглалт

Хөрөнгө шилжүүлэх тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/103 дугаар тушаалын хавсралтад заасан хөрөнгийг шилжүүлэхдээ 700,142.13 хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” зарчим, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Зөвлөмж

Хөрөнгө данснаас хасах, шилжүүлэхдээ элэгдлийг үнэн зөв тооцоолон шийдвэрлүүлж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Үйл ажиллагааны зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,458,673.78	56,273,389.55
33	АВЛАГА	15,062.23	-
33500	Бусад авлага	15,062.23	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	15,062.23	-
35	БАРАА МАТЕРИАЛ	52,443,611.55	56,273,389.55
35300	Бэлэн бүтээгдэхүүн	22,671,265.75	30,224,141.75
35400	Хангамжийн материал	29,772,345.80	26,049,247.80
35410	Бичиг хэргийн материал	3,115,820.00	1,776,350.00
35420	Аж ахуйн материал	17,917,065.00	18,544,150.00
35440	Түлш, шатах тослох материал	293,000.00	330,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,046,460.80	5,398,747.80
35600	Мал амьтад	1,400,000.00	-
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,207,272,289.24	11,270,791,576.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,207,272,289.24	11,270,791,576.46
39200	Биет хөрөнгө	4,206,287,914.24	11,270,275,951.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,211,980,000.00	4,816,915,170.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 350,998,333.20	- 421,197,999.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,344,690.50	140,312,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 107,573,857.27	- 93,791,336.81
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	550,578,767.64	7,074,587,419.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 423,441,329.97	- 368,031,896.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	343,173,677.59	327,845,798.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 207,442,367.65	- 221,030,039.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 3,333,333.40	- 5,333,333.44
39300	Биет бус хөрөнгө	984,375.00	515,625.00
39301	Програм хангамж	3,200,000.00	3,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 2,215,625.00	- 2,684,375.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,259,730,963.02	11,327,064,966.01
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	4,259,730,963.02	11,327,064,966.01
51	Засгийн газрын хувь оролцоо	6,753,678,238.38	6,753,678,238.38
51101	Засгийн газрын оруулсан капитал	6,753,678,238.38	6,753,678,238.38
51200	Хуримтлагдсан үр дүн	- 2,508,164,598.21	4,571,936,504.78
51210	Өмнөх үеийн үр дүн	- 2,508,164,598.21	- 2,495,397,498.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,067,334,002.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,217,322.85	1,450,222.85
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,259,730,963.02	11,327,064,966.01

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,717,296,449.92	10,803,494,085.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,638,250.00	7,376,796,485.26
120	Нийтлэг татварын бус орлого	37,638,250.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,317,942,485.26
120005	Түрээсийн орлого	37,638,250.00	58,854,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,679,658,199.92	3,426,697,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,615,672,700.00	3,420,697,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,615,672,700.00	3,420,697,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	6,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	6,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	63,985,499.92	-
133003	Хөрөнгийн	63,985,499.92	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,047,627,484.34	3,709,995,065.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,361,688,990.21	3,645,878,722.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,854,204,434.22	3,645,878,722.10
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,361,688,990.21	3,297,676,287.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,027,465,697.86	2,970,293,515.24
210101	Үндсэн цалин	2,908,080,097.86	2,852,743,915.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	119,385,600.00	117,549,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	334,223,292.35	327,382,772.44
210201	Тэтгэврийн даатгал	212,938,623.13	210,078,359.12
210202	Тэтгэмжийн даатгал	24,873,152.37	23,460,883.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,128,599.41	29,326,103.07
210204	Ажилгүйдлийн даатгал	6,025,720.02	5,865,220.46
210205	Эрүүл мэндийн даатгал	60,257,197.42	58,652,206.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,312,448.00	50,584,687.89
210301	Гэрэл, цахилгаан	32,481,470.00	31,893,909.00
210302	Түлш, халаалт	14,212,475.00	15,495,954.00
210303	Цэвэр, бохир ус	2,618,503.00	3,194,824.89
2104	Хангамж, бараа материалын зардал	29,863,094.32	24,385,595.36
210401	Бичиг хэрэг	11,306,230.00	4,219,780.00
210402	Тээвэр, шатахуун	7,128,300.00	6,393,500.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,014,539.32	3,305,302.36
210404	Ном, хэвлэл	3,758,198.78	6,703,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,330,450.00	780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,325,376.22	2,983,513.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,335,146.00	9,143,322.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,015,446.00	263,984.00
210604	Урсгал засвар	5,319,700.00	8,879,338.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,608,053.12	85,625,960.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,405,568.12	27,150,789.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,567,510.00	2,407,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	138,417.00	511,960.00
210807	Газрын төлбөр	261,700.00	261,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	39,234,858.00	53,294,011.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,396,702.57	178,462,868.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,397.00	4,352,801.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,000.00	78,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	333,306,305.57	174,031,967.30
212	ТАТААС	-	17,711,700.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	17,711,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,423,050.12	46,404,643.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	192,423,050.12	46,404,643.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	192,423,050.12	46,404,643.43
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	- 330,331,034.42	7,093,499,019.73
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	145,192,509.73	26,165,016.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	145,192,509.73	24,193,816.74
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,971,200.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(475,523,544.15)	7,067,334,002.99

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлангийн үеийн үр дүн	-	-	-	-
2016 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(2,508,164,598.21)	4,259,730,963.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	12,767,100.00	12,767,100.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	12,767,100.00	-	12,767,100.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлангийн үеийн үр дүн	-	-	7,067,334,002.99	7,067,334,002.99
2017 оын 12 сарын 31-р үлдэгдэл	6,753,678,238.38	1,450,222.85	4,571,936,504.78	11,327,064,966.01

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,653,310,950.00	3,485,551,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,638,250.00	58,854,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	37,638,250.00	58,854,000.00
120005	Түрээсийн орлого	37,638,250.00	58,854,000.00
120006	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,615,672,700.00	3,426,697,600.00
120007	Улсын төвлөрсөн төсвөөс	3,615,672,700.00	3,420,697,600.00
120008	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,615,672,700.00	3,420,697,600.00
120009	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	6,000,000.00
120013	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	6,000,000.00
131002	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,653,310,950.00	3,485,551,600.00
131003	УРСГАЛ ЗАРДАЛ	3,342,336,553.44	3,236,761,325.45
131004	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,459,887,899.88	3,360,535,356.57
131005	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,342,336,553.44	3,236,761,325.45
131006	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,045,866,929.96	2,914,402,839.58
131007	Үндсэн цалин	2,706,705,429.96	1,573,225,539.58
131008	Нэмэгдэл	-	913,602,900.00
131009	Унаа хоолны хөнгөлөлт	143,678,700.00	156,740,400.00
1311	Урамшуулал	142,340,000.00	250,200,000.00
131101	Гэрээт ажлын хөлс	53,142,800.00	20,634,000.00
131103	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	296,469,623.48	322,358,485.87
131104	Тэтгэврийн даатгал	296,469,623.48	322,358,485.87
132003	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,312,448.00	50,584,687.89
132004	Гэрэл, цахилгаан	32,481,470.00	31,893,909.00
132005	Түлш, халаалт	14,212,475.00	15,495,954.00
132006	Цэвэр, бохир ус	2,618,503.00	3,194,824.89
132007	Хангамж, бараа материалын зардал	16,816,228.32	16,067,279.36
1330	Бичиг хэрэг	3,270,650.00	3,920,760.00
133001	Тээвэр, шатахуун	5,849,000.00	5,330,000.00
133002	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,014,539.32	3,305,302.36
133003	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,168,750.00	780,000.00
133004	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,513,289.00	2,731,217.00
133005	Эд хогшил, урсгал засварын зардал	10,995,265.00	13,759,564.00
1340	Багаж, техник, хэрэгсэл	2,753,215.00	1,409,974.00
134001	Урсгал засвар	8,242,050.00	12,349,590.00
134002	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,122,905.12	43,257,999.87
134003	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,448,800.00	29,400,100.00
300001	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
II	Даатгалын үйлчилгээ	2,258,010.00	2,258,000.00
21	Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	309,500.00
210	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,365,185.12	1,228,699.87
21	Газрын төлбөр	261,700.00	261,700.00
2101	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,479,710.00	7,800,000.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210101	Бараа үйлчилгээний бусад зардал	304,500.00	104,500.00
210102	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	304,500.00	104,500.00
210103	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,423,050.12	125,016,243.43
210104	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	60,899,900.00
210105	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	-
210106	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	60,899,900.00
2102	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	184,895,400.12	4,693,413.21
210201	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,895,400.12	4,693,413.21
210202	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,527,650.00	59,422,930.22
210203	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,527,650.00	59,422,930.22
210204	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
210205	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
210206	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,458,785,700.00	3,420,128,669.78	(38,657,030.22)	99.17%
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,458,785,700.00	3,420,128,669.78	(38,657,030.22)	99.17%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,458,681,200.00	3,359,124,269.78	(99,556,930.22)	99.14%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,458,681,200.00	3,359,124,269.78	(99,556,930.22)	94.67%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	3,001,086,800.00	2,914,402,839.58	(86,683,960.42)	99.32%
210101	Үндсэн цалин	1,713,769,500.00	1,573,225,539.58	(140,543,960.42)	98.77%
210102	Нэмэгдэл цалин	913,602,900.00	913,602,900.00	-	100.00%
210103	Унаа хоолны нэмэгдэл	156,740,400.00	156,740,400.00	-	100.00%
210104	Урамшуулал	172,000,000.00	250,200,000.00	78,200,000.00	100.00%
210105	Гэрээт ажлын хөлс	44,974,000.00	20,634,000.00	(24,340,000.00)	98.38%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	332,119,500.00	321,051,899.08	(11,067,600.92)	99.26%
210201	Тэтгэврийн даатгал	332,119,500.00	321,051,899.08	(11,067,600.92)	99.26%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,006,100.00	50,584,687.89	(3,421,412.11)	93.66%
210301	Гэрэл, цахилгаан	30,948,300.00	31,893,909.00	945,609.00	100.00%
210302	Түлш, халаалт	20,343,400.00	15,495,954.00	(4,847,446.00)	81.91%
210303	Цэвэр, бохир ус	2,714,400.00	3,194,824.89	480,424.89	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	16,069,100.00	16,067,279.36	(1,820.64)	99.99%
210401	Бичиг хэрэг	3,422,300.00	3,920,760.00	498,460.00	99.96%
210402	Тээвэр, шатахуун	6,654,600.00	5,330,000.00	(1,324,600.00)	99.99%
210403	Шуудан,холбоо, интернетийн төлбөр	3,225,800.00	3,305,302.36	79,502.36	100.00%
210405	Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	1,214,800.00	780,000.00	(434,800.00)	100.00%
210406	БҮТЭЗүйлс	1,551,600.00	2,731,217.00	1,179,617.00	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,400,000.00	13,759,564.00	2,359,564.00	100.00%
210601	Багаж,техник хэрэгсэл	2,000,000.00	1,409,974.00	(590,026.00)	100.00%
	Хаадамд хамгааллын хэрэгсэл	400,000.00	-	(400,000.00)	0.00%
210604	Урсгал засвар	9,000,000.00	12,349,590.00	3,349,590.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,999,700.00	43,257,999.87	(741,700.13)	92.43%
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,141,800.00	29,400,100.00	(741,700.00)	89.25%
210802	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.00%
210803	Даатгалын үйлчилгээ	2,258,000.00	2,258,000.00	-	100.00%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	309,500.00	-	100.00%
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	1,228,700.00	1,228,699.87	(0.13)	100.00%
210807	Газрын төлбөр	261,700.00	261,700.00	-	100.00%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	7,800,000.00	7,800,000.00	-	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,500.00	104,500.00	-	100.00%

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,500.00	104,500.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	60,899,900.00	60,899,900.00	100.00%
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	60,899,900.00	60,899,900.00	100.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	60,899,900.00	60,899,900.00	100.00%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	100.00%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	100.00%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	100.00%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	100.00%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,458,785,700.00	3,420,128,669.78	(38,657,030.22)	100.00%
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,088,100.00	58,854,000.00	20,765,900.00	100.00%
120005	Төрийн өмч түрээслүүсний орлого	38,088,100.00	58,854,000.00	20,765,900.00	100.00%
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,420,697,600.00	3,361,274,669.78	(59,422,930.22)	100.00%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,420,697,600.00	3,361,274,669.78	(59,422,930.22)	100.00%
132000	Орон нутгийн төсвөөс санхүүжих		-	-	100.00%
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,000,000.00	6,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	6,000,000.00	6,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	1,306,586.79	1,306,586.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,306,586.79	1,306,586.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,306,586.79	1,306,586.79
210201	Тэтгэврийн даатгал	-	1,306,586.79	1,306,586.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,693,413.21	4,693,413.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,693,413.21	4,693,413.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,693,413.21	4,693,413.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,000,000.00	6,000,000.00
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-	-
120005	Төрийн өмч түрээслүүсний орлого	-	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	6,000,000.00	6,000,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-
132000	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	6,000,000.00	6,000,000.00
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-	-

